



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/08

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.3, 50.5, Сангийн сайдын 2021 оны "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа урамшууллыг зохицуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын газрын харуул хамгаалалтын үйлчилгээний сонгон шалгаруулах тендэрийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: М.Тайванжаргал

Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: А.Долгорсүрэн

Баруунбаян-Улаан сумын татварын улсын байцаагч

Гишүүн: Б.Одсүрэн

Иргэний төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу нээлттэй зохион байгуулж, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахиж, шудрага ил тод байдлыг хангаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Үнэлгээний хорооны дарга (М.Тайванжаргал), гишүүдэд даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасаг (А.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЭРДЭНЭСУВД



621001016